



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СТАТИСТИКИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ГҮНИЙ ХУДГИЙН 2013 ОНЫ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

АГУУЛГА

	Хуудасны дугаар
I.Тооллогын зохион байгуулалт	1
Хууль, эрх зүйн үндэслэл	
Тооллогын зорилго, ач холбогдол	
Тооллогын удирдлага, зохион байгуулалт	
Тооллогын бэлтгэл ажил	
Тооллого явуулсан хугацаа, хамрах хүрээ, арга зүй	
Тооллогын үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, аргачлал	
Тооллогын чанарын шалгалт	
Мэдээлэл боловсруулах, үр дүнгийн хүснэгт	
II.Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа худаг	8
III.Худгийн зориулалт	15
IV.Худгийн гүний хэмжээ	20
V.Дүгнэлт	23
Цаашид анхаарах асуудал	

Хүснэгт 1. Нийт худгийн тоо, ашиглалтын байдлаар
Хүснэгт 2. Нийт худгийн тоо, эзэмшигчээр
Хүснэгт 3. Нийт худгийн тоо, зөвшөөрөлтэй эсэхээр, эзэмшигчээр
Хүснэгт 4. Нийт худгийн тоо, худгийн төрлөөр
Хүснэгт 5. Худгийн төрөл, цахилгаан үүсвэр төвлөрсөн системд холбогдсон байдлаар
Хүснэгт 6. Нийт худгийн тоо, барилгын хийцээр
Хүснэгт 7. Барилгагүй худаг, эзэмшигчээр
Хүснэгт 8. Нийт худгийн тоо, ашиглаж эхэлсэн оноор
Хүснэгт 9. Нийт худгийн тоо, шинжилгээ хийлгэсэн эсэх
Хүснэгт 10. Нийт худгийн тоо, зориулалтаар
Хүснэгт 11. Нийт худгийн тоо, шинжилгээ хийлгэсэн эсэх, зориулалтаар
Хүснэгт 12. Нийт худгийн тоо, шинжилгээ хийлгэсэн эсэх, зориулалтаар
Хүснэгт 13. Ашиглаж байгаа нийт худгийн тоо, усан сангийн багтаамжаар
Хүснэгт 14. Нийт худгийн тоо, зориулалтаар
Хүснэгт 15. Худагтай өрхийн нэг өдрийн усны хэрэглээгээр
Хүснэгт 16. Нийт худгийн тоо, зориулалтаар
Хүснэгт 17. Ашиглаж байгаа нийт худгийн тоо, ААНБ-ын 1 хоногийн усны хэрэглээгээр
Хүснэгт 18. Нийт худгийн тоо, гүний хэмжээгээр
Хүснэгт 19. 1-19 метрийн гүнтэй худгийн тоо, төрлөөр
Хүснэгт 20. Нийт худгийн тоо, хөрс, геологийн тогтолцоогоор
Хүснэгт 21. 1-19 метрийн гүнтэй худгийн тоо, эзэмшигч, шинжилгээ хийлгэсэн эсэх
Хүснэгт 22. Худгийн мэдээллийн сангийн баяжилт

Зураг 1. Нийт худгийн тоо, дүүргээр
Зураг 2. Худгийн тоо, эзэмшигчээр
Зураг 3. Барилгагүй худгийн төрөл, хувиар
Зураг 4. Барилгатай гүний худаг
Зураг 5. Барилгагүй гүний худаг
Зураг 6. Худгийн тоо, анх гаргасан оноор, 1992-2013 он
Зураг 7. Нийт худгийн тоо, зориулалтаар
Зураг 8. Усан сантай нийт худаг, усан сангийн багтаамжаар
Зураг 9. Усан сантай гүний худаг
Зураг 10. Нийт худаг, худгийн гүний хэмжээгээр
Зураг 11. Гар аргаар ухсан худаг
Зураг 12. Мэдээллийн сангийн баяжилт

Хавсралт зураг 1. Тооллогын асуулгын хуудасны шивэлт хийх вэб програм
Хавсралт зураг 2. Стандарт газрын зурагт байршуулсан худаг
Хавсралт зураг 3. Satellite газрын зурагт байршуулсан худаг
Хавсралт зураг 4. Satellite газрын зурагт байршуулсан худаг
Хавсралт зураг 5. Hybrid буюу хосолмол газрын зурагт байршуулсан худаг
Хавсралт зураг 6. Тооллогын вэб програмын үр дүнгийн хүснэгт

НИЙСЛЭЛИЙН ГҮНИЙ ХУДГИЙН 2013 ОНЫ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

I. ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хууль, эрх зүйн үндэслэл

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” болон “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилт”-д нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өрх болон аж ахуйн нэгжийн ашиглаж буй гүний худгийн тооллого зохион байгуулахаар төлөвлөсөн.

Гүний худгийн тооллогыг дараах хууль тогтоомж, эрх зүйн актыг үндэслэн зохион байгуулав. Тухайлбал:

- Монгол Улсын Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт
- Байгаль орчны (хуучин нэрээр) сайдын 2006 оны 269 дүгээр тушаалаар баталсан “Усны тоо бүртгэл явуулах журам”
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан “Санамж бичиг”-ийн 1.1.4.8 дах заалт
- Нийслэлийн Засаг даргын 2013 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн А\621 дүгээр захирамж

Тооллогын зорилго, ач холбогдол

Тооллогын үндсэн зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа гүний худгийн талаар дэлгэрэнгүй түвшинд судалж, олон улсын стандартад нийцсэн, харьцуулахуйц тоон үзүүлэлт, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, салбарын бодлого боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бий болгоход чиглэгдсэн.

Энэ тооллогыг явуулснаар дараах үр дүнд хүрэв. Тухайлбал:

- Энэ удаагийн тооллогоор гүний төдийгүй хөрсний ус ашиглаж буй нийт худгийг тоолов.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа нийт худгийн байршил, эзэмшигч, ашиглалтын байдлын талаарх анхан шатны бүртгэл эрс сайжирч, бодит байдалд нийцэв.
- Нийт худгийн тоон болон орон зайн дэлгэрэнгүй мэдээллийн санг бүрдүүлж, цаашид баяжилтыг тухай бүр хийх боломжтой болгов.
- Тооллогод нийслэлийн нийт нутаг дэвсгэр, нийт худгийг бүхэлд нь хамруулснаар усны нөөцийн ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх, усны эх үүсвэрийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх ажлын чиглэлийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг сайжруулсан.
- Энэ чиглэлийн бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлгээ өгөх зэрэгт шаардлагатай мэдээллийг бий болгов.

Тооллогын удирдлага, зохион байгуулалт

Нийслэлийн Засаг даргын 2013 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн А\621 дүгээр захирамжаар нийслэлийн хэмжээнд гүний худгийн тооллогыг зохион байгуулах НИЙСЛЭЛИЙН КОМИСС-ыг байгуулсан.

Нийслэл хотод гүний худгийг зохион байгуулах комиссын даргаар Нийслэлийн Засаг даргын экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ, орлогч даргаар нийслэлийн Статистикийн газрын дарга Ч.Баянчимэг, нарийн бичгийн даргаар Нийслэлийн Статистикийн газрын мэргэжилтэн Н.Мөнхбаяр нар ажиллав.

Нийслэлийн гүний худгийн тооллогын комиссын гишүүдээр дараах байгууллагын төлөөлөл оролцон ажилласан. Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын дарга
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Өмчийн харилцааны газрын дарга
- Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
- Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга
- Ус сувгийн удирдах газар НӨҮГ-ын дарга

Гүний худгийн тооллогыг дүүргийн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах, өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын ажилд дэмжлэг үзүүлж ажиллах үүрэг бүхий дүүргийн тооллогын комисс, ажлын хэсгийг тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллууллаа.

Энэ удаа Статистикийн газар нь тооллогын ажлыг дагнан хариуцаж, нийт худгийн бүртгэл, мэдээллийн сан, өмнөх тооллогын мэдээлэл болон мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг судлан тооллогын асуулгыг боловсруулах, тооллогын ажилтныг бэлтгэх, тоолох, тооллогын мэдээллийг цуглуулж, боловсруулан тооллогын тайланг гаргав.

Байгаль орчин, ногоон хөгжлийн газар нь гүний худаг бүрийг тооллогод бүрэн хамруулах нөхцлийг бүрдүүлж, зохицуулах үүргийг хариуцах, тооллогын бэлтгэл ажилд шаардлагатай уст цэгийн анхан шатны болон улсын тоо бүртгэл, тооллогын мэдээллийг нутаг дэвсгэр, тоолох нэгж бүрээр дэлгэрэнгүй гаргаж өгөх, тооллогын асуулга, зааварт мэргэжлийн зөвлөмж өгөх, нийслэл, дүүрэг, хорооны түвшний тооллогын ажлын хэсэг бүрт усны чиглэлийн мэргэжилтнийг ажиллуулах, тооллогын дүн мэдээллийг үндэслэн уст цэгийн мэдээллийн санг шинэчлэн байгуулах, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох ажил үүргийн хуваарьтай ажиллав.

Тооллогыг илүү үр дүнтэй, олон улсын аргачлал, стандартад нийцэхүйц байлгах үүднээс тооллогын удирдамж, төлөвлөгөө, асуулга, түүнийг нөхөх заавар, зохион байгуулалтын бусад асуудлаар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Туул голын ай сав газрыг хамгаалах газар, Ус сувгийн удирдах газар зэрэг байгууллагын мэргэжилтнүүдийн зөвлөмж, саналыг авч ажилласан.

Тооллогын бэлтгэл ажил

Гүний худгийн тооллогын бэлтгэлийг дараах байдлаар хангав. Тухайлбал:

1. Нийслэлийн Статистикийн газраас Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас 2011 онд хийсэн тооллогын мэдээллийг тохирох форматаар хөрвүүлж, гүний худгийн байршлыг Google map дээр тулгуурласан вэб програм хийж байрлуулсан.
2. Гүний худгийн 2011 оны улсын тооллогод хамрагдсан болон нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар, Өмчийн харилцааны газар болон бусад байгууллагын бүртгэлтэй худгийн байршлыг зэрэгцүүлж, тооллогод хамрагдах жагсаалтыг гаргав.
3. Гүний худгийн тооллогын асуулгын хуудасны загварыг хийж, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Туул голын ай сав газрыг хамгаалах газар, нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Ус сувгийн удирдах газар зэрэг холбогдох байгууллага, ажилтны саналыг авч тусган, нөхөх зааврын хамт боловсруулав.
4. Тооллогын нийслэл, дүүргийн комиссыг байгуулж, тооллогын бүх үе шатыг хамруулсан нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан батлуулж, ажиллав.
5. Дүүргийн хороонд тооллогын комиссыг зохион байгуулж, тоологч, шалгагч нарыг сонгон шалгаруулж, анкетыг нийслэлийн тооллогын комисст хүлээн авч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.
6. Гүний худгийн байршлыг 2013 оны байдлаар дүүрэг, хороогоор гаргаж, тоологч нарт лавлагаа болгож өгсөн.
7. Тооллогын асуулгын хуудас, нөхөх заавар, GPS ашиглах заавар зэрэг тоологчид шаардлагатай бүх гарын авлага, сургалтын материалыг тоолох товоос өмнө хэвлэн бэлэн болгосон.
8. Тоологчийн үнэмлэх, тооллогод хамрагдсан өрх, аж ахуйн нэгж, байгууллагад олгох тооллогын гэрчилгээг өнгөтөөр хэвлэсэн.
9. Тооллогын мэдээллийг боловсруулах програм хангамжийн бодлогын даалгаврыг боловсруулж, мэдээлэл боловсруулалтын үе шат бүрийг автоматжуулах боломжийг бүрдүүлэв.
10. Гүний худгийн тооллогыг нийслэлийн хэмжээнд чанартай, сайн зохион байгуулж явуулах, удирдлагын шуурхай байдлыг хангаж ажиллах зорилгоор 9 дүүргийн Засаг дарга нарт тооллогын бэлтгэл, тоолох, мэдээлэл боловсруулах үе шатанд анхаарах нийтлэг асуудлыг Нийслэлийн тооллогын комиссын даргаас албан бичгээр хүргүүлсэн.
11. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А\621 дүгээр захирамжаар гүний худгийн тооллогыг явуулахад шаардагдах 31.2 сая төгрөгийг батлуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулав. Тооллогын төсөвт дараах хэмнэлтийг гаргасан. Үүнд:
 - ✓ Нийслэл, дүүргийн тооллогын комиссын ажилтнууд ажлын нэмэлт хөлс, урамшуулалгүй ажиллав.

- ✓ Тооллогын асуулгын хуудас, нөхөх заавар, тооллогын тайлан бичиж боловсруулах зэрэг ажлыг НСГ, БОНХГ-ын ажилтнууд нэмэлт хөлс, урамшуулалгүй хийсэн.
 - ✓ Тээврийн зардлыг зах зээлийн дундаж үнээс доогуур тогтоов.
 - ✓ Тооллогын бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн зардлыг нийслэл, дүүргийн статистикийн албадын жилийн үйл ажиллагааны зардалтай уялдуулан “нэмэлт зардал” байхаар тооцов.
 - ✓ Тооллогын мэдээлэл боловсруулах програм хангамжийг зах зээлийн үнээс доогуур буюу аль болох судалгааны бэлэн програмыг ашиглахаар тооцсон.
 - ✓ GPS төхөөрөмжийг зөвхөн 10 ширхэгийг худалдан авч, бусад шаардлагатай төхөөрөмжийг Үндэсний Статистикийн хорооноос үнэ төлбөргүй түр хугацаагаар зээлж ашиглах, гар утасны GPS ашиглах зэргээр зардлыг хэмнэв.
 - ✓ Тоолох хугацаа 30 хоног боловч өдөрт тоолох худгийн тоог 5-8 байхаар тогтоож тоолох өдрийг 15 өдөр болгон багасгасан. Ингэснээр тоологч, шалгагчид олгох ажлын хөлс, хоол, унаа, утасны зардлыг хэмнэв.
 - ✓ Тоологчийн ажлын урамшууллыг тоолсон худгийн тоо, тооллогын асуулгын хуудсыг бүрэн нөхүүлсэн байдал зэргээр ажлын чанар, хугацаа, алдаагүй байдлыг харгалзан олгосон. Өөрөөр хэлбэл, “хэн их худгийг зааврын дагуу тоолно, түүнд илүү урамшуулал” гэсэн зарчмыг баримтлав.
 - ✓ Тооллогын явцад болон мэдээлэлд хийх мониторингийн замын чиглэлийг зөвхөн гүний худаг олноор байршсан, өмнөх тооллого болон анхан шатны бүртгэлийн мэдээлэл зөрүүтэй чиглэлд явахаар тооцож, тээврийн зардлыг хэмнэв.
 - ✓ Гүний худгийн тооллогыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай зарим зардлыг тухай бүр дүүргийн төсвөөс санхүүжүүлэв.
12. Тооллогын комиссын нарийн бичгийн дарга, тоологч, шалгагч, шивэгч нарт сургалт явуулах сургагч багшийг Нийслэлийн Статистикийн газраас урьдчилан бэлтгэж, сургалтыг чанартай зохион байгуулсан нь тооллогын үр дүнд эерэгээр нөлөөлсөн.

Тооллого явуулсан хугацаа, хамрах хүрээ, арга зүй

Тооллогыг 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал 33 хоногийн хугацаанд явууллаа.

Тооллогын явцын талаарх мэдээллийг 50 тоологч бүрээс 3 хоног тутамд авч, дүүргийн тооллогын комисс, хорооны Засаг даргатай хамтран шаардлагатай зохицуулалтыг шуурхай хийж байв. Тооллогын өдрүүдэд нийслэл, дүүргийн тооллогын комисс өдөр бүр 8-22 цагийн хооронд жижүүр гарган ажиллаж, телефон утсаар лавласан асуулт болон үүссэн асуудлыг тухай бүр хариулт өгөх, зохицуулах зэргээр шийдвэрлэсэн.

Тооллогын маягтад тусгагдсан асуултууд 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаагаар буюу тооллогын товын байдлаар нөхөх зарчмыг баримталсан.

Тооллогод нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа өрх, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөлд байгаа нийт худгийг хамруулав.

Гүний худаг бүр дээр биечлэн очиж, мэдээлэл нь нийтлэг, иж бүрэн байх нөхцлийг хангах зорилгоор тооллогын батлагдсан маягтын үзүүлэлт нэг бүрийг зааврын дагуу нөхөж бичих аргаар мэдээллийг цуглуулсан.

2013 онд хийх гүний худгийн тооллогод GPS ашиглан худаг нэг бүрийн байршлыг тогтоов.

Тооллогын үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, аргачлал

Тооллогын асуулгын хуудсыг боловсруулахдаа Байгаль орчны сайдын 2006 оны 269 дугаар тушаалын “Усны тоо бүртгэл явуулах журам”-ыг баримталж, уст цэгийн тухай ойлголт, бүртгэлийн асуулгын үзүүлэлтүүд, “Худгийн бүртгэлийн дугаар” маягыг үндэслэв. Энэ удаагийн тооллогын асуулгын хуудас, үзүүлэлтүүдийн тодорхойлолт, асуулгын хуудсыг нөхөх зааврын төслийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд урьдчилан танилцуулж, албан ёсны зөвшөөрлийг авсан.

Тооллогод “Засаг захиргааны ангилал”, “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал” (ISIC-4.0), Монгол Улсын бүсчлэлийн код (аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны код) зэргийг нэгдсэн журмаар мөрдөн ажилласан.

Худгийн ойлголт	тодорхойлолт
Өрөмдмөл худаг	Харьцангуй бага голч (150, 200, 250, 300, 350, 400 мм)-той, 30 метрээс доош гүнтэй цооног бүхий цахилгаан буюу дизель хөдөлгүүртэй ус өргүүштэй худаг.
Богино яндант худаг	Харьцангуй бага голч (150, 200, 250мм)-той, 30 метр хүртэл гүнтэй цооног бүхий худаг.
Бетон хашлагат уурхайн худаг	КШК-30 гэдэг өрмийн машинаар харьцангуй их голч (1 метр)-той, 30 метр хүртэл гүнтэй өрөмдөж гаргасан, ханыг нь бетон цагиргуудаар бэхэлсэн худаг.
Энгийн уурхайн/ гар худаг/	хөрс, геологийн тогтолцоог ажиглаж судалсны үндсэн дээр хөрсний өнгөн хэсэгт ус байх магадлал бүхий газарт гараар ухаж гаргасан цооногийн ханыг мод, чулуу зэрэг материалаар хашиж бэхэлсэн худаг.

Тооллогын чанарын шалгалт

Тооллогын явц, хамралт, тооллогын үеэр асуулгын хариултын үнэн зөв, бодит байдлыг хянах зорилгоор нийслэл, дүүргийн тооллогын комиссоос хяналт шалгалт хийж ажиллав. Тоологч нарын ажлын явцтай танилцаж, лавлагаа болгож өгсөн жагсаалтад буй худгийг тооллогод бүрэн хамруулсан эсэх, тухайн хорооны нутаг дэвсгэрт байгаа бүх худгийг тоолсон эсэх, тооллогын асуулгыг аль болох бүрэн нөхөх, GPS-ийг ашиглаж худгийн байршлыг зөв тогтоосон эсэх, тооллогын асуулгын хариултыг бусад мэдээлэл, бүртгэлтэй уялдуулахад гол анхаарлаа хандуулсан.

Тооллогын хамралт ямар түвшинд болсныг тухайн хорооны Засаг даргаар үнэлүүлж, тодорхойлолт авсан бөгөөд асуулгын дутуу хариултыг хороо, дүүргийн Засаг даргын холбогдох ажлын албад, ажилтантай хамтран нөхөх зэргээр нилээд хүчин чармайлтыг гарган ажиллав.

Тооллогын асуулгын хуудсын бүх үзүүлэлтийн хоорондын уялдааг ердийн буюу бүх асуулт бүрэн хариулагдсан эсэх, асуулт хоорондын уялдаа, gps-р давхардсан худаг байгаа эсэх, байрлал зөв эсэхийг шалгах, үсрэлт зөв байгааг шалгах, үнэмшилтэй утгын буюу байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэхийг шалгах, статистик анализ дээр тулгуурласан хамаарлын болон логик шалгалт, утгуудын хоорондын уялдаа, логик холбоо, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэх зэрэг шалгалтуудыг хийж, илэрсэн алдаанд холбогдох засварыг хийсэн.

Мэдээлэл боловсруулах, үр дүнгийн хүснэгт

Гүний худгийн энэ удаагийн тооллогоор газар зүйн мэдээллийн системийн сансарын зургийг ашиглаж, орон зайн мэдээллийн сан үүсгэх зорилт тавьсан нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулж байсан бусад тооллогоос давуутай болов.

Тооллогын мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, шалгах, засварлах болон GPS-ийн мэдээллийг боловсруулах, үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах зэрэг тооллогын бүх үе шаттай холбоотой програм хангамжийн бодлогын даалгаврыг боловсруулж, 5 програмыг боловсруулсан.

- **Тооллогын асуулгын хуудасны шивэлт хийх вэб програм** (хавсралт зураг 1)

Тооллогын асуулгын хуудсыг цахим хэлбэрт шилжүүлэх шивэлтийн вэб програм нь маягтын дагуу асуулт бүрийн хариултыг оруулна. Програм нь давхар цэг, алдаатай өгөгдөл, буруу шивэлтийг хянаж, алдаатай өгөгдөл оруулахгүй, мэдээлэл нэмж, засварлаж, устгадаг байхаар хийгдсэн.

Програмыг Статистикийн газрын вэб сервер дээр байрлуулсан тул интернеттэй орчноос мэдээллийг баяжуулах боломжтой. Програмд хийсэн үйлдэл бүрийг хадгалж, хэн хэзээ ямар өөрчлөлт оруулсныг харж болно.

Мэдээллийн санд өөрчлөлт хийх, баяжуулах тусгай эрхтэй ажилтан зөвхөн компьютераас төдийгүй гар утас болон бусад электрон төхөөрөмжөөс хандаж болно.

- **GPS төхөөрөмжөөс дата бааз руу хөрвүүлэх програм**

Энэ програм нь GPS төхөөрөмжөөс өгөгдлийг хуулж, газрын зурагт харуулах өгөгдлийн сангийн формат руу хөрвүүлдэг програм юм. Програм нь давхардлын цэгийг тогтоож, алдаатай өгөгдлийг илрүүлж чадна. Жишээ нь: Монгол улсын газар зүйн байрлалаас өөр өгөгдлөөр (өндөр, байршил гэх мэт) оруулж байгаа буруу мэдээллийг илрүүлнэ.

- **Гар утасыг GPS болгон ашиглах, мэдээллийг дата бааз руу хөрвүүлэх програм**

Өнөө үед ашиглаж буй iOS, Android гэсэн үндсэн 2 системийн гар утасны HeadGPS програмыг идэвхижүүлж, энэ удаагийн худгийн тооллогод гар утсыг GPS төхөөрөмж болгон ашиглав. Гар утсаар тогтоосон GPS өгөгдлийг мэдээллийн сан руу хөрвүүлж, тухайн худгийг газрын зурагт байршуулах програмыг боловсруулсан. Энэ програм нь давхардлын цэгийг тогтоож, алдаатай өгөгдлийг илрүүлнэ.

- **Газрын зураг дээр тооллогын үр дүнг харуулах програм** (хавсралт зураг 2, 3, 4, 5)

Газрын зурагт тооллогын үр дүнг харуулах програм нь шивэгдсэн мэдээллийг GPS-ын өгөгдөлтэй холбож, Google Map-ыг ашиглан онлайнаар газрын зурагт мэдээллийг харуулна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт тоологдсон нийт худгийг стандарт (хавсралт зураг 2) болон satellite (Хавсралт зураг 3, 4) буюу хиймэл дагуулаас авсан газрын зураг, hybrid (Хавсралт зураг 5) буюу хосолмол газрын зурагт тус тус байршуулж, уг байршлын цэг дээр дарахад тухайн худгийн тооллогын асуулгын хариулт мэдээлэл бүрэн гарна.

- **Үр дүнгийн хүснэгтийг хүссэн үзүүлэлтээр гаргах вэб програм (хавсралт зураг 6)**

Тооллогын үр дүнгийн хүснэгт (Хавсралт зураг 6) гаргах вэб програм нь тооллогын асуулгын дагуу нэн шаардлагатай 13 хүснэгтийг хороо, дүүрэг, нийслэлийн дүнгээр гаргана. Уг програмд хандах эрхтэй ажилтны хийсэн өөрчлөлт, баяжилтаар үр дүнгийн хүснэгт шууд өөрчлөгдөж байхаар програмыг боловсруулсан.

Үүнээс гадна худгийн тооллогын мэдээллийн сангаас Access, Excel програм ашиглан хүссэн үр дүнгийн хүснэгт гаргах боломжтой.

Тооллогын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг Нийслэлийн Статистикийн газар хариуцан хийв. Цаг үеийн нөхцөл байдал, ялангуяа гүний худгийн талаарх мэдээллийн хэрэгцээтэй байдлыг харгалзан энэ удаагийн тооллогын үр дүн, тайланг батлагдсан төлөвлөгөө, хугацаанаас нь нэг сар гаруйн өмнө боловсруулав.

Тооллогын үр дүнгийн үзүүлэлтүүдийг албан ёсны болон захиргааны статистикийн холбогдох мэдээлэл, бусад тооллого, анхан шатны бүртгэлтэй харьцуулан хянаж, эцсийн үр дүнг боловсруулсан.

Тооллогын мэдээлэлд үндэслэсэн үр дүнгийн тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, нийслэлийн удирдлага, холбогдох агентлагт, хэрэглэгчдэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаана.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн нууцлалтай уялдуулан тооллогын нийт асуулгын хуудас, тооллогын мэдээллийн сан, орон зайн мэдээллийн санд нэвтрэх эрхийн хамт зөвхөн Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.

II. НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙГАА ХУДАГ

Гүний худгийн тооллогын товын үеэр нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 5331 худгийг тоолов. Тоологдсон нийт худгийн 89.6 хувь нь буюу 4774 худгийг өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд ашиглаж байна.

Хүснэгт 1. Нийт худгийн тоо, ашиглалтын байдлаар

Байршил	Нийт худгийн тоо	Ашиглалтын байдал				
		Ашиглаж байгаа	Ашиглаагүй	Үүнээс шалтгаанаар		
				Эхлээгүй	Түр зогсоосон	Бүрэн зогсоосон
Багануур	148	142	6	1	2	3
Багахангай	33	25	8	6	2	0
Баянгол	233	203	30	4	6	20
Баянзүрх	1,093	1,001	92	26	44	22
Налайх	256	225	31	6	15	10
Сонгинохайрхан	950	845	105	13	68	24
Сүхбаатар	1,309	1,190	119	57	45	17
Хан-Уул	1,089	944	145	69	62	14
Чингэлтэй	220	199	21	2	16	3
Дүн	5,331	4,774	557	184	260	113

Зураг 1. Нийт худгийн тоо, дүүргээр

Энэ удаагийн тооллогоор Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хамгийн их буюу 1309 худгийг тоолсон байна.

Сүхбаатар дүүргийн нийт худгийн 63.7 хувь буюу 835 худаг нь зөвхөн 19, 20 хорооны нутаг дэвсгэрт буюу зуслангийн газарт байна.

Зуслангийн болон гэр хороолол, газар тариалан эрхлэх нутаг дэвсгэр бүхий Баянзүрх, Сонгинохайрхан Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт нийт худгийн 83.3 хувь нь байна. Ялангуяа Сүхбаатар дүүргийн 19, 20 хороо, Баянзүрх дүүргийн 20, 23 хорооны Улиастайн эцэс, Хужирбулан, Гачуурт, Хан-Уул дүүргийн 4, 11, 12, 13, 14 хорооны Нүхтийн ам, Зайсангийн ам, Нисэх, Биокомбинат, Шувуун фабрик орчим, Сонгинохайрхан дүүргийн 21 хороонд худаг их байна.



Нийслэл хотод тоологдсон нийт худгийн 65.5 хувь буюу 3491 худгийг өрх, 33.0 хувь буюу 1757 худгийг аж ахуйн нэгж, байгууллага эзэмшиж байна.

Хүснэгт 2. Нийт худгийн тоо, эзэмшигчээр


Байршил	Нийт худгийн тоо	Эзэмшигчээр		
		Өрх	ААНБ	Эзэмшигч тодорхойгүй
Багануур	148	52	94	2
Багахангай	33	5	28	0
Баянгол	233	22	211	0
Баянзүрх	1,093	764	314	15
Налайх	256	37	219	0
Сонгинохайрхан	950	608	327	15
Сүхбаатар	1,309	1,174	96	39
Хан-Уул	1,089	648	433	8
Чингэлтэй	220	181	35	4
Дүн	5,331	3,491	1,757	83

Тооллогын товын үеэр 200 орчим худгийн эзэмшигч тодорхойгүй, тооллогын асуулгын хариултыг авч чадахгүй байв.

Эдгээр эзэмшигч нь тодорхойгүй худгийн байршил, хаягийг тухайн хорооны Засаг дарга, дүүргийн ЗДТГ-ын холбогдох байгууллага, ажилтан, гүний худаг гаргадаг аж ахуйн нэгжүүдэд өгч, тэднээс өгсөн мэдээллийн дагуу “эрэн сурвалжлах” ажлыг зохион байгуулсан.

Энэ ажлын үр дүнд тооллогын хугацаанд 117 худгийн мэдээллийг бүрэн бүрдүүлж, харин 83 худгийн мэдээллийг бүрэн бүрдүүлж чадаагүй.

Зураг 2. Худгийн тоо, эзэмшигчээр



Багануур, Багахангай, Баянгол, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байгаа нийт худгийн дийлэнх хувийг аж ахуйн нэгж, байгууллагууд эзэмшиж байна.

Бусад дүүрэгт өрхийн эзэмшлийн худаг илүү хувийг эзэлж байна. Тухайлбал Сүхбаатар дүүргийн нийт худгийн 89.7 хувийг өрхийн эзэмшлийн, харин Баянгол дүүргийн нийт худгийн 90.6 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн худаг эзэлж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт гаргасан нийт худгийн 58.0 хувь буюу 3094 худаг нь албан ёсоор зөвшөөрлийг зохих байгууллагаас нь авчээ. Харин нийт худгийн 42.0 хувь нь зөвшөөрөлгүй байна. Ялангуяа зөвшөөрөлгүй нийт худгийн 78.5 хувь нь өрхийн эзэмшилд байна.

Хүснэгт 3. Нийт худгийн тоо, зөвшөөрөлтэй эсэхээр, эзэмшигчээр

Байршил	Зөвшөөрөлтэй худаг, бүгд	үүнээс			Зөвшөөрөл байхгүй худаг, бүгд	үүнээс		
		Өрх	ААНБ	Эзэмшигч тодорхойгүй		Өрх	ААНБ	Эзэмшигч тодорхойгүй
Багануур	126	42	84	0	22	10	10	2
Багахангай	25	1	24	0	8	4	4	0
Баянгол	167	13	154	0	66	9	57	0
Баянзүрх	587	323	258	6	506	441	56	9
Налайх	152	12	140	0	104	25	79	0
Сонгинохайрхан	526	300	225	1	424	308	102	14
Сүхбаатар	755	648	72	35	554	526	24	4
Хан-Уул	594	266	327	1	495	382	106	7
Чингэлтэй	162	131	30	1	58	50	5	3
Дүн	3,094	1,736	1,314	44	2,237	1,755	443	39

Нийслэлийн нутаг дэвсгэрт өрөмдлөг 4385 худаг, богино яндант 152 худаг, энгийн уурхайн 720 худаг, бетон хашлагат уурхайн 74 худгийг тоолов. Инженерийн хийцтэй буюу өрөмдлөг болон богино яндант худаг нийт тоолсон худгийн 85.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Нийт худгийн тоо, худгийн төрлөөр

Байршил	Нийт худгийн тоо	Худгийн төрлөөр			
		Өрөмдлөг	Богино яндант	Энгийн уурхай	Бетон хашлагат уурхайн
Багануур	148	123	10	14	1
Багахангай	33	29	1	1	2
Баянгол	233	220	0	11	2
Баянзүрх	1,093	817	75	170	31
Налайх	256	252	0	4	0
Сонгинохайрхан	950	841	24	85	0
Сүхбаатар	1,309	1,038	33	238	0
Хан-Уул	1,089	856	9	186	38
Чингэлтэй	220	209	0	11	0
Дүн	5,331	4,385	152	720	74

Аж ахуйн нэгж, байгууллага болон өрхийн эзэмшлийн нийт худгийн 82.9 хувь буюу 4419 худаг нь төвлөрсөн цахилгааны шугам сүлжээнд холбогджээ. Харин 912 худаг нь энгийн уурхайн худаг болон бие даасан цахилгаан үүсгүүртэй өрөмдлөг худаг байна.

Хүснэгт 5. Худгийн төрөл, цахилгаан үүсвэр төвлөрсөн системд холбогдсон байдлаар

Худгийн төрөл	Төвлөрсөн цахилгааны шугамд холбогдсон	Үүнээс		Төвлөрсөн цахилгааны шугамд холбогдоогүй	Үүнээс	
		Өрх	ААНБ		Өрх	ААНБ
Өрөмдлөг	3931	2391	1540	373	229	144
Богино яндант	139	111	28	13	12	1
Энгийн уурхай	307	285	22	411	404	7
Бетон хашлагат уурхайн	42	29	13	32	30	2
Дүн	4419	2816	1603	829	675	154

Нийт худгийн 21.7 хувь нь бетон, 28.9 хувь нь тоосгон, 12.1 хувь нь модон барилгатай байна. Харин нийт тоологдсон худгийн хамгийн их 37.3 хувь нь хамгаалалтын ямар нэг барилгагүй, ялангуяа өрх хашаандаа худаг гаргаж, ил задгай ашиглаж байв.

Хүснэгт 6. Нийт худгийн тоо, барилгын хийцээр

Дүүрэг	Нийт худгийн тоо	Барилгын хийцээр			
		Бетон	Тоосгон	Модон	Бусад
Багануур	148	42	16	14	76
Багахангай	33	9	13	2	9
Баянгол	233	12	71	5	145
Баянзүрх	1,093	113	427	163	390
Налайх	256	11	158	28	59
Сонгинохайрхан	950	329	218	83	320
Сүхбаатар	1,309	356	311	244	398
Хан-Уул	1,089	240	242	80	527
Чингэлтэй	220	47	82	27	64
Дүн	5,331	1,159	1,538	646	1,988

Зураг 3. Барилгагүй худгийн төрөл, хувиар



Барилгагүй нийт худгийн 74.0 хувь нь өрөмдлөг буюу газрын гүнээс гадарга хүртэл ус дамжуулах төмөр хоолойг ямар нэгэн хамгаалалтгүй ил гаргасан худаг байна.

Барилгагүй нийт худгийн 4.0 хувийг богино яндант худаг, 20.0 хувийг энгийн уурхайн худаг, 2.0 хувийг бетон хашлагт уурхайн худаг эзэлж байна.

Зураг 4. Барилгатай гүний худаг



Зураг 5. Барилгагүй гүний худаг



Хүснэгт 7. Барилгагүй худаг, эзэмшигчээр

Худгийн төрөл	бетон		тоосгон		модон		барилгагүй	
	өрх	ААНБ	өрх	ААНБ	өрх	ААНБ	өрх	ААНБ
Өрөмдлөг	686	354	776	661	280	93	878	576
Богино яндант	9	5	29	12	12	4	73	8
Энгийн уурхайн	46	2	31	2	238	7	374	18
Бетон хашлагат уурхайн	9	1	4	10	7		39	4
Дүн	750	362	840	685	537	104	1364	606


Нийт худгийн 1.7 хувь буюу 89 худаг нь 1974 оноос өмнө, 12.2 хувь буюу 652 худаг нь 1975-2001 оны хооронд, 47.0 хувь буюу 2505 худаг нь 2002-2010 оны хооронд, 34.2 хувь буюу 1823 худаг нь 2011-2013 оны хооронд гаргасан худгууд байна. Харин 4.9 хувь буюу 262 (83 худгийн эзэмшигч тодорхойгүй) худгийн анх гаргасан буюу ашигласан хугацааг эзэмшигч нь мэдэхгүй байв.

Худгийг анх гаргасан буюу ашигласан хугацаагаар нь ангилбал, нийт худгийн 81.2 хувь буюу 4328 худгийг 2002 оноос хойш сүүлийн 10 гаруй жилийн турш ашиглажээ. Эдгээр худгийн 42.1 хувь буюу нийт худгийн 34.2 хувь нь сүүлийн 3 жилд гаргасан худаг эзэлж байна. Худаг гаргах үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд олширсон, Улаанбаатар хотод усан хангамжийн үйлчилгээ хангалтгүй байгаа, газар тариалан эрхлэх зэргээс шалтгаалж худгийн тоо сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгджээ.

Хүснэгт 8. Нийт худгийн тоо, ашиглаж эхэлсэн оноор

Байршил	Нийт худгийн тоо	Үүнээс ашигласан хугацаагаар				
		1974-өөс өмнө	1975-2001 он	2002-2010 он	2011-2013 он	Тодорхойгүй
Багануур	148	0	27	86	33	2
Багахангай	33	6	4	15	8	0
Баянгол	233	12	56	87	78	0
Баянзүрх	1,093	30	205	527	303	28
Налайх	256	2	51	127	76	0
Сонгинохайрхан	950	9	63	462	377	39
Сүхбаатар	1,309	3	141	563	460	142
Хан-Уул	1,089	27	91	521	417	33
Чингэлтэй	220	0	14	117	71	18
Дүн	5,331	89	652	2,505	1,823	262

Зураг 6. Худгийн тоо, анх гаргасан оноор, 1992-2013 он



*2013 онд гаргасан худгийн тоог тооллогын товоор буюу 2013 оны 09 сарын 15-ны өдөр хүртэл гаргасан худгаар тооцов.

Энэ удаагийн тооллогод хамрагдсан нийт худгийн 46.9 хувь нь зохих байгууллагад хандаж усны лабораторийн шинжилгээг албан ёсоор хийлгэжээ. Харин нийт худгийн 53.1 хувь нь лабораторийн шинжилгээгүй усыг ашиглаж байна. Лабораторийн шинжилгээ хийлгээгүй нийт худгийн 70.6 хувь нь өрхийн эзэмшилд байна.

Хүснэгт 9. Нийт худгийн тоо, шинжилгээ хийлгэсэн эсэх

Байршил	Шинжил-гээтэй худаг	үүнээс		Шинжил-гээгүй худаг	үүнээс		
		Өрх	ААНБ		Өрх	ААНБ	Эзэмшигч тодорхойгүй
Багануур	47	26	21	101	26	73	2
Багахангай	18	1	17	15	4	11	0
Баянгол	132	12	120	101	10	91	0
Баянзүрх	536	306	230	557	458	84	15
Налайх	131	6	125	125	31	94	0
Сонгинохайрхан	408	238	170	542	370	157	15
Сүхбаатар	595	538	57	714	636	39	39
Хан-Уул	477	235	242	612	413	191	8
Чингэлтэй	157	130	27	63	51	8	4
Дүн	2501	1,492	1,009	2830	1,999	748	83


III. ХУДГИЙН ЗОРИУЛАЛТ

Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа нийт худгийн 50.8 хувь буюу 2709 худгийг унд, ахуйн зориулалтаар, 9.1 хувийг газар тариалан, 7.3 хувийг үйлдвэрлэл, 1.3 хувийг мал аж ахуйд дангаар нь зориулж ашиглаж байна. Харин 1680 худгийг давхар буюу олон зориулалтаар ашигладаг гэжээ.

Хүснэгт 10. Нийт худгийн тоо, зориулалтаар

Байршил	Нийт худгийн тоо	Үүнээс зориулалтаар				
		Унд, ахуйн	Мал усалгаа	Газар тариалан	Үйлдвэрлэл	Давхар
Багануур	148	32	9	10	66	31
Багахангай	33	17	4	0	1	11
Баянгол	233	93	1	1	84	54
Баянзүрх	1,093	544	9	90	36	414
Налайх	256	179	1	17	23	36
Сонгинохайрхан	950	452	27	82	56	333
Сүхбаатар	1,309	923	7	207	11	161
Хан-Уул	1,089	308	8	64	112	597
Чингэлтэй	220	161	2	13	1	43
Дүн	5,331	2,709	68	484	390	1,680

Зураг 7. Нийт худгийн тоо, зориулалтаар



Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж олноор байрласан Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт тухайн зориулалтын худгийн тоо их байна.

Багануур, Баянгол, Хан-Уул дүүрэгт үйлдвэрлэлийн зориулалтаар нилээд тооны худгийг ашиглаж байна.

Лабораторийн шинжилгээ хийлгээгүй, эзэмшигч нь тодорхой нийт 2747 худгийн 40.1 хувь буюу 1101 худгийг зөвхөн ундны зориулалтаар хэрэглэдэг гэж хариулсан байна. Ундны зориулалтаар ашиглаж буй шинжилгээгүй нийт худгийн 79.2 хувь нь өрхийн эзэмшилд байна.

Хүснэгт 11. Нийт худгийн тоо, шинжилгээ хийлгэсэн эсэх, зориулалтаар

Зориулалт	Нийт	Шинжил-гээтэй худгийн тоо	Үүнээс эзэмшигчээр		Шинжил-гээгүй худгийн тоо	Үүнээс эзэмшигчээр		Эзэмшигч тодорхойгүй худгийн тоо
			Өрх	ААНБ		Өрх	ААНБ	
Унд, ахуйн	2709	1581	1009	572	1101	872	229	27
Мал усалгаа	68	14	7	7	53	41	12	1
Газар тариалан	481	68	38	30	413	360	53	0
Үйлдвэрлэл	393	164	17	147	226	22	204	3
Давхар зориулалт	1680	674	421	253	954	704	250	52
Дүн	5331	2501	1492	1009	2747	1999	748	83

Тооллогод хамрагдсан нийт худгийн 22.8 хувь буюу 1217 худаг усны нөөцийг хуримтлуулан ашиглах усан сантай байна.

Хүснэгт 12. Нийт худгийн тоо, усан сантай эсэх, зориулалтаар

Зориулалт	Усан сангүй худгийн тоо	Усан сантай худгийн тоо	Үүнээс усан сангийн багтаамжаар			
			1 тонн	1.1-4.9 тонн	5-20 тонн	21 -ээс дээш тонн
Унд, ахуйн	2093	616	337	146	81	52
Мал усалгаа	58	10	4	4	2	0
Газар тариалан	415	69	22	16	14	17
Үйлдвэрлэл	257	133	18	23	47	45
Давхар	1291	389	113	105	126	45
Дүн	4114	1217	494	294	270	159

Усан сантай нийт худгийн 50.6 хувь нь унд, ахуйн зориулалтаар, 0.8 хувь нь мал усалгааны зориулалтаар, 5.7 хувь нь үйлдвэрлэлийн зориулалтаар, 32.0 хувь нь давхар зориулалтаар гүний усыг усан санд нөөцлөн хэрэглэдэг байна.

Хүснэгт 13. Ашиглаж байгаа нийт худгийн тоо, усан сангийн багтаамжаар

Байршил	Усан сангүй худгийн тоо	Усан сантай худгийн тоо	Үүнээс усан сангийн багтаамжаар			
			1 тонн	1.1-4.9 тонн	5-20 тонн	21 тонноос дээш
Багануур	109	39	17	13	7	2
Багахангай	21	12	3	4	2	3
Баянгол	144	89	12	17	27	33
Баянзүрх	932	161	66	39	36	20
Налайх	156	100	19	37	35	9
Сонгинохайрхан	727	223	71	66	58	28
Сүхбаатар	1,071	238	182	38	12	6
Хан-Уул	824	265	63	66	83	53
Чингэлтэй	130	90	61	14	10	5
Дүн	4,114	1,217	494	294	270	159

Худаг эзэмшигч өрх нэг өдөрт дунджаар 57 литр ус ашиглаж байна. Тухайлбал 578 худгаас 100 хүртэлх литр ус, 445 худгаас 100-200 хүртлэх литр ус, 260 худгаас 200-500 хүртэлх литр ус, 371 худгаас 0.5 тонн ус буюу хагас тонн усыг нэг өдөрт дунджаар унд, ахуйн зориулалтаар хэрэглэдэг гэжээ.

Хүснэгт 14. Нийт худгийн тоо, зориулалтаар

Зориулалт	Өрхийн эзэмшилд ашиглаж буй худгийн тоо	Үүнээс өдрийн хэрэглээгээр				
		1-99 литр	100-199 литр	200-499 литр	500-с дээш литр	Тодорхойгүй
Унд, ахуйн	1731	578	445	260	371	77
Мал усалгаа	35	7	5	9	14	
Газар тариалан	353	58	60	111	124	
Үйлдвэрлэл	29	1	1	6	21	
Давхар	1053	144	146	246	469	48
Дүн	3201	788	657	632	999	125

Нийслэлийн худагтай нийт өрхийн 24.6 хувь нь 100 литр хүртэл, 20.5 хувь нь 100-200 литр хүртэл, 19.7 хувь нь 200-500 литр хүртэл, хамгийн их хувь болох 31.2 хувь нь хагас тонноос их усыг нэг өдөрт тус тус хэрэглэж байна.

Хүснэгт 15. Худагтай өрхийн нэг өдрийн усны хэрэглээгээр

Байршил	Өрхийн ашиглаж байгаа худгийн тоо	Үүнээс				
		1-99 литр	100-199 литр	200-499 литр	500-с дээш литр	Тодорхойгүй
Багануур	50	1	1	3	45	0
Багахангай	4	0	0	0	4	0
Баянгол	19	3	4	2	10	0
Баянзүрх	714	192	203	146	161	12
Налайх	31	1	7	12	11	0
Сонгинохайрхан	546	123	102	97	216	8
Сүхбаатар	1,080	322	191	193	277	97
Хан-Уул	591	106	85	148	251	1
Чингэлтэй	166	40	64	31	24	7
Дүн	3,201	788	657	632	999	125

Худаг эзэмшиж буй аж ахуйн нэгж, байгууллагууд өдөрт дунджаар 137 тонн усыг хэрэглэж байна.

Аж ахуйн нэгжүүд 13 худгийг мал усалгаанд, 60 худгийг газар тариаланд, 296 худгийг үйлвэрлэлийн зориулалтаар, 449 худгийг олон төрлийн зориулалтаар, 709 худгийг ундны зориулалтаар ашиглаж байна.

Хүснэгт 16. Нийт худгийн тоо, зориулалтаар

Зориулалт	ААНБ-ын ашиглаж буй худгийн тоо	Үүнээс өдрийн хэрэглээгээр				
		0.9 тонн хүртэлх	1-5 тонн хүртэлх	5-49 тонн	50-с дээш тонн	Тодорхойгүй
Унд, ахуйн	709	252	190	51	201	15
Мал усалгаа	13	4	7	2	0	
Газар тариалан	60	17	32	9	2	
Үйлдвэрлэл	296	54	121	87	34	
Давхар	449	139	197	80	20	13
Дүн	1527	466	547	229	257	28

Аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн нийт худгийн 30.5 хувь буюу 466 худаг нь 1 тонн хүртэлх ус, 35.8 хувь нь 1-5 тонн хүртэлх ус, 15.0 хувь нь 5-50 тонн хүртэлх ус, 16.8 хувь нь 50-с дээш тонн усыг өдөрт хэрэглэдэг гэж хариулжээ.

Хүснэгт 17. Ашиглаж байгаа нийт худгийн тоо, ААНБ-ын 1 хоногийн усны хэрэглээгээр

Байршил	ААНБ-ын ашиглаж буй худгийн тоо	Үүнээс				
		0.9 тонн хүртлэх	1-5 тонн хүртлэх	5-49 тонн	50-с дээш тонн	Тодорхойгүй
Багануур	90	1	36	53	0	0
Багахангай	21	1	11	3	6	0
Баянгол	184	67	49	19	49	0
Баянзүрх	281	71	79	26	101	4
Налайх	194	54	65	19	56	0
Сонгинохайрхан	295	139	123	21	6	6
Сүхбаатар	79	21	36	7	3	12
Хан-Уул	353	96	136	80	36	5
Чингэлтэй	30	16	12	1	0	1
Дүн	1,527	466	547	229	257	28

Зураг 8. Усан сантай нийт худаг, усан сангийн багтаамжаар



Зураг 9. Усан сантай гүний худаг



Нийт усан сантай худгийн 40.6 хувь буюу 494 худгийг 1 тонн хүртэлх багтаамжтай худаг, 24.2 хувь буюу 294 худгийг 1-5 тонн хүртэлх багтаамжтай худаг, 22.2 хувь буюу 270 худгийг 5-20 тонны багтаамжтай худаг, үлдсэн 13.1 хувь буюу 159 худгийг 21 тонноос дээш багтаамжтай худаг тус тус эзэлж байна.

IV. ХУДГИЙН ГҮНИЙ ХЭМЖЭЭ

Зураг 10. Нийт худаг, худгийн гүний хэмжээгээр

Энэ удаагийн тооллогод хамрагдсан нийт 5331 худгийн 18.0 хувь буюу 957 худаг нь 1-19 метр хүртэл гүн, 40.4 хувь буюу 2152 худаг нь 20-54 метр хүртэл гүн, 31.3 хувь буюу 1668 худаг нь 55-99 метр хүртэл гүн, 5.6 хувь буюу 299 худаг нь 100 метрээс дээш гүнтэй байна.

Харин 4.8 хувь буюу 255 худгийн гүний хэмжээг эзэмшигч нь мэдэхгүй, эсвэл худгийг эзэмшигч нь тодорхойгүй тул тогтоож чадсангүй.



Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 19 метр хүртэл гүнтэй худгийн тоо бусад дүүргээс харьцангуй их байна.

Хүснэгт 18. Нийт худгийн тоо, гүний хэмжээгээр

Дүүрэг	Нийт худгийн тоо	Үүнээс худгийн гүний хэмжээгээр				
		1-19 метр	20-54 метр	55-99 метр	100 метрээс дээш	Тодорхойгүй
Багануур	148	17	48	15	66	2
Багахангай	33	3	11	18	1	0
Баянгол	233	39	174	12	8	0
Баянзүрх	1,093	247	538	241	42	25
Налайх	256	10	112	117	17	0
Сонгинохайрхан	950	133	344	388	48	37
Сүхбаатар	1,309	262	431	427	46	143
Хан-Уул	1,089	233	420	343	63	30
Чингэлтэй	220	13	74	107	8	18
Дүн	5,331	957	2,152	1,668	299	255

Усыг 1-19 метрийн гүнээс гарган ашиглаж буй нийт 957 худаг нийслэлийн нутаг дэвсгэрт тоологдов. Хамгийн бага гүнтэй 957 худгийн 83.3 хувь нь үндсэндээ хөрсний усыг хэрэглэж байна. Энэ ангилалд багтах 691 худаг нь албан ёсны зөвшөөрөлгүй бөгөөд энгийн уурхайн буюу гараар ухаж гаргасан байна.

Хүснэгт 19. 1-19 метрийн гүнтэй худгийн тоо, төрлөөр

Дүүрэг	Нийт	Худгийн төрлөөр			
		Өрөмдлөг	Богино яндант	Энгийн уурхай	Бетон хашлагат уурхайн
Багануур	17	2	2	12	1
Багахангай	3	1	0	1	1
Баянгол	39	27	0	11	1
Баянзүрх	247	35	25	163	24
Налайх	10	6	0	4	0
Сонгинохайрхан	133	37	14	82	0
Сүхбаатар	262	24	11	227	0
Хан-Уул	233	26	3	180	24
Чингэлтэй	13	2	0	11	0
Дүн	957	160	55	691	51

Эдгээр худгийн 16.7 хувь буюу 160 нь өрөмдлөг худаг байна. Худгийн төрлөөс шалтгаалан худгийг гүний, хөрсний усны гэж ангилбал нийслэлийн нутаг дэвсгэрт гүний усны 4279 худаг, хөрсний усны 797 худаг байна.

Хүснэгт 20. Нийт худгийн тоо, хөрс, геологийн тогтолцоогоор

	Нийт худгийн тоо	үүнээс		
		Гүний	Хөрсний	Тодор- хойгүй
Багануур	148	131	15	2
Багахангай	33	31	2	0
Баянгол	233	221	12	0
Баянзүрх	1093	856	212	25
Налайх	256	252	4	0
Сонгинохайрхан	950	817	96	37
Сүхбаатар	1309	928	238	143
Хан-Уул	1089	852	207	30
Чингэлтэй	220	191	11	18
Дүн	5331	4279	797	255

1-19 метр гүнтэй нийт худгийн 88.2 хувь буюу 844 нь лабораторийн шинжилгээ огт хийлгэж байгаагүй гэж хариулжээ.

Хүснэгт 21. 1-19 метрийн гүнтэй худгийн тоо, эзэмшигч, шинжилгээ хийлгэсэн эсэх

Байршил	Шинжил-гээтэй худгийн тоо	Үүнээс эзэмшигчээр		Шинжил-гээгүй худгийн тоо	Үүнээс эзэмшигчээр	
		ААНБ	Өрх		ААНБ	Өрх
Багануур	9	0	9	8	1	7
Багахангай	0	0	0	3	1	2
Баянгол	10	9	1	29	23	6
Баянзүрх	37	11	26	210	7	203
Налайх	1	1	0	9	5	4
Сонгинохайрхан	9	3	6	124	16	108
Сүхбаатар	33	1	32	229	5	224
Хан-Уул	11	4	7	222	9	213
Чингэлтэй	3	0	3	10	0	10
Дүн	113	29	84	844	67	777

Хөрсний ус гэдэг нь газрын доорх усны нөөц, газрын гадаргын усны хоорондын холбоог тэжээгч нь юм. Өөрөөр хэлбэл, голын эрэг дагасан намаг балчиг, усны ундарга газрын хэсэгт хөрсний ус илүү ихээр хуримтлагдаж, байгаль орчинд хэд хэдэн үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, газрын доороос оргилон гарахдаа ургамлын үндсийг тэжээнэ, хөрсний бохирдлыг цэвэрлэнэ, түүнчлэн газрын доорх усны тэжээлийн үндсэн эх сурвалж, гол мөрнүүд рүү цутгах урсацыг сайжруулах үүрэг гүйцэтгэнэ.

Хур борооны 10 орчим хувийг хөрсөөрөө шингээнэ. Хөрсний ус газрын гүнээс доош 10 орчим метрт бий. Өөрөөр хэлбэл гар аргаар ухсан худгийн ус бол хөрсний ус.

Мэргэжилтний хэлсэн дээрх тайлбарыг үндэслэвэл 1-19 метрийн гүн худгийн усыг лабораторийн шинжилгээгүй ундны зориулалтаар хэрэглэж байгаа өрх, хүн ам нь элдэв бохирдолтой ус хэрэглэж байна гэж өнгөц дүгнэж болно. Тооллогын үед тоологч нараас Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт 1-2 метрийн гүнээс хөрсний усыг ундны ус болгон ашиглаж буй олон өрх байгааг дурдаж байсан.

Зураг 11. Гар аргаар ухсан худаг



ДҮГНЭЛТ

Зураг 12. Мэдээллийн сангийн баяжилт

Энэ удаагийн тооллогоор нийт 5331 худаг тоолсон нь 2011 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас зохион байгуулсан тооллогын дүнгээс 3671 худгаар, нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын мэдээллийн сангийн энэ оны бүртгэлтэй худгийн тооноос 3160-аар тус тус илүү байна.


- Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллогод зайлшгүй хамрагдах худгийн жагсаалтыг бүрдүүлэхдээ Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2011 оны тооллого, Хөдөө аж ахуйн улсын 2012 оны тооллого, Мал, тэжээвэр амьтдын 2012 оны тооллого, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2013 оны нийтийн зориулалттай өмчийн тооллого, Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын 2013 оны мэдээллийн сан, Ус сүвгийн удирдах газрын 2013 оны мэдээллийн сан, зарим хорооны Засаг даргын худгийн бүртгэл зэрэг мэдээллийн олон эх үүсврийг ашиглаж, хооронд нь тулгалт хийсэн.

- Эдгээр мэдээллийн эх үүсврүүдээс GPS өгөгдөлтэй мэдээллийг боловсруулан Google Map-ыг ашиглан орон зайн мэдээллийн санг байгуулсан. Тооллогын дараа тооллогын мэдээллээр орон зайн мэдээллийн санг баяжуулан шинэчлэв.

- Тооллогод зайлшгүй хамрагдах худгийн жагсаалт, тооллогын газрын зургийг тоологч бүрт өгч, хорооны Засаг дарга, түүний ажлын албаны ажилтнуудтай хамтран хорооны нутаг дэвсгэрт самналт хийсэн тул тоолсон худгийн тоо өмнөх тооллого, мэдээллээс даруй 3 дахин нэмэгдсэн.

- Тооллогын үеэр тоологч бүр хорооны Засаг дарга, дүүргийн Газрын албаны ажилтнуудтай хамтран эзэмшигч нь тодорхойгүй олон худгийн мэдээллийг тодруулж, эзэмшигчийг тогтоосон нь тооллогын үр дүнд эерэгээр нөлөөлсөн.

- Өмнөх тооллого, бүртгэлүүдийн үр дүнг энэ удаагийн тооллогын үр дүнтэй тулгаж, тоолсон худаг бүрийг газрын зурагт байршуулснаар худгийн давхардал арилж, бүртгэлгүй байсан 2000 орчим худгийг бүртгэлтэй болгов.



- Тооллогод хамрагдсан худгийн эзэмшигч бүрт нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт албан ёсоор бүртгүүлэх, зохих зөвшөөрөл, худгийн паспортыг авах, худгийн усанд лабораторийн шинжилгээг зайлшгүй хийлгэх ёстойг анхааруулж, тооллогод хамрагдсан гэрчилгээг олгосон.
- Энэ удаагийн тооллогоор газар зүйн мэдээллийн системийн сансарын зургийг ашиглаж, орон зайн мэдээллийн санг үүсгэсэн нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулж байсан бусад тооллогоос давуутай болов. Ингэснээр гүний болон хөрсний ус ашиглалтыг байдлыг хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд нутаг дэвсгэрийн байршлаар харах боломжтой.
- Энэ удаагийн тооллогоор нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа нийт худгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, олон улсын стандартад нийцсэн, харьцуулахуйц тоон үзүүлэлт, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, салбарын бодлого боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бий болгож чадав. Гүний худгийн тооллогыг зохион байгуулахдаа нийслэлийн нутаг дэвсгэр байгаа нийт худгийг тоолох, ингэснээр хөрсний ус ашиглалтын байдал, ундны усны эрүүл ахуйн өнөөгийн байдлын талаар тодорхой мэдээллийг цуглуулан боловсруулав.

Хүснэгт 22. Худгийн мэдээллийн сангийн баяжилт

дүүрэг	БОНХЯ-ны 2011 оны тооллогоор тоолсон гүний худаг	Нийслэлийн БОНХГ-ын мэдээллийн санд бүртгэлтэй худаг (2013.05 сар)	Нийслэлийн худгийн тооллогоор тоолсон нийт худгийн тоо (2013.09.15)	Үүнээс гүний худгийн тоо
Багануур	39	29	148	131
Багахангай	12	1	33	31
Баянгол	99	121	233	221
Баянзүрх	486	494	1093	856
Налайх	65	52	256	252
Сонгинохайрхан	341	395	950	817
Сүхбаатар	165	534	1309	928
Хан-Уул	213	412	1089	852
Чингэлтэй	240	133	220	191
нийт	1660	2171	5331	4279

- Тооллогын асуулгын хуудас бүрийг зураг болгож, тооллогын мэдээллийн сан, орон зайн мэдээллийн санд хандах эрхийн хамт нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.
- Дүүргийн худгийн тооллогын комисст тухайн дүүргийн нутаг дэвсгэр байгаа нийт худгийн мэдээллийн санг хүлээлгэн өгнө.

Цаашид анхаарах асуудал:

Энэ удаагийн тооллогын бэлтгэл ажил, тоолох үе шат, тооллогын үр дүнг боловсруулах явцаас харахад цаашид дараах асуудлуудыг анхаарч, хэрэгжүүлэх саналтай байна. Тухайлбал:

- Худгийн анхан шатны бүртгэлийг сайжруулах.

Худгийн мэдээллийн сан нь зөвхөн нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын хариуцах ажил биш юм. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хороо, дүүргийн Засаг дарга нар өөрийн нутаг дэвсгэрт байгаа уст цэг, худаг бүрийг бүртгэж, ашиглалт, хамгаалалтад нь хяналт тавьж, бүртгэлийг жил бүр нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт мэдээлж байх үүрэгтэй байдаг. Үүний дагуу хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан уст цэгийг бүртгэх, тоолох бүртгэлийн маягт, нөхөх заавар, журам зэргийг баримталж ажиллах нь зүйтэй.

- Захиргааны статистикийн мэдээллийг сайжруулах.

Энэ удаагийн тооллогын дүнтэй зөвхөн Ус сувгийн газрын худгийн бүртгэлийн дүн, Нийслэлийн Статистикийн газраас зохион байгуулсан Хөдөө аж ахуйн тооллого, Мал, тэжээвэр амьтдын тооллогын худгийн дүн нийцэж байв.

Монгол Улсын Статистикийн тухай хуулиар албан ёсны статистикийн үйл ажиллагааг Үндэсний Статистикийн хороо, түүний орон нутгийн салбарууд олон улсын аргачлал, арга зүйгээр эрхлэн явуулдаг. Харин захиргааны статистикийн мэдээллийг Засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр цуглуулж, боловсруулж ашигладаг. Эдгээр байгууллагууд, ялангуяа нутгийн захиргааны байгууллагууд захиргааны статистикийн мэдээллийн маягт, нөхөх заавар, мэдээлэл цуглуулах, боловсруулах арга зүйг баримталдаггүй, шинэ мэдээлэл бий болгохдоо Үндэсний Статистикийн хорооноос арга зүйн зөвлөмж, зөвшөөрөл авалгүй ажилладаг тул бүртгэл, мэдээллийн зөрүү их, бодит байдалд нийцэхгүй тоон мэдээллийг бий болгодог. Жишээ нь: БОНХЯ-ны 2011 оны тооллого, нийслэлийн БОНХГ-ын мэдээллийн сан бодит байдлаас хол зөрүүтэй байгаа нь тооллого, бүртгэл явуулах наад захын аргачлал, зааврыг баримтлаагүйтэй шууд холбоотой байна.

Нийтийн зориулалттай өмчийн тооллогоор зарим дүүргийн ЗДТГ-ын өмчлөлд бүртгэгдсэн худгийг “энэ худаг ашиглалтгүй болж, нурж, орхигдсныг хорооны Засаг даргад мэдэгдэж, өөрийн хөрөнгөөр сэргээн засварласан тул өөрийн нэр, эзэмшилд бүртгүүлнэ” гэсэн тохиолдол энэ удаагийн худгийн тооллогын үеэр цөөнгүй гарсан.

Иймд хорооны Засаг дарга, дүүргийн ЗДТГ, нийслэлийн БОНХГ хоорондын мэдээлэл солилцох урсгал, хариуцах ажилтан, мэдээллийн давтамж, хугацааг тодорхой, ойлгомжтой болгож, БОНХЯ-наас баталсан худгийн бүртгэл, тооллого хийх заавар, журмын дагуу биеэр очиж тоолох, бүртгэх зэргээр ажиллах шаардлагатай байна.

- Мэдээллийг боловсруулах техник хэрэгслийг сайжруулах. Энэ удаагийн тооллогоор орон зайн мэдээллийн санг байгуулсан бөгөөд баяжилтыг хийсэн тухай бүрт үндсэн үр дүнгийн хүснэгтүүд байнга шинэчлэгдэнэ. Нийслэлийн БОНХГ-ын худгийн бүртгэл, асуудал хариуцсан ажилтны ажлын компьютерийг өнөө цагийн хэрэглээний програм, интернет ашиглах хүчин чадал, хурдтай болгож сайжруулах шаардлагатай байна.

- Бүртгэл, мэдээллийн маягт, заавар, давтамж, урсгалд өөрчлөлт оруулах.

БОНХЯ-наас баталсан уст цэг, худгийн анхан шатны бүртгэл, тооллогын маягт, нөхөх зааврыг олон улсын арга аргачлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай

болжээ. Ялангуяа худгийн зөвшөөрөл олгох, худаг гаргах, худаг ашиглах үйл ажиллагаатай уялдуулж, мэдээллийн маягт, урсгал, давтамжийг өөрчлөх нь зүйтэй. Худаг, уст цэгийн анхан шатны бүртгэл, мэдээллийн боловсруулалт хангалтгүй байгаа нэг шалтгаан нь бүртгэл, тооллогын маягт нь хэтэрхий их асуулттай, зөвхөн мэргэжлийн ажилтан асууж, хариултыг нөхөхөөр боловсруулсан байдаг. Хэрэв заавал ийм асуулгатай байх шаардлагатай бол бүртгэл, тооллого явуулахын өмнө тоологчийн сургалтыг чанартай хийж байх, тоологч нарыг шалгаруулж сонгох, тоологчийн ажлын хөлсийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулан олгох зэргээр мэдээлэл цуглуулах үйл явцын чанарт анхаарах.

- Худаг гаргах зөвшөөрөл олгох, ашиглалтад хяналт тавих ажлын зохион байгуулалтыг өөрчлөх. Худаг гаргадаг аж ахуйн нэгжүүд тухайн өрх, аж ахуйн нэгжийг худагтай болох зөвшөөрөл авсан эсэхийг үл харгалзан худаг гаргаж өгдөг зөрчил түгээмэл болжээ. Нийслэлд усан хангамжийн үйлчилгээ хангалтгүй байгаагаар уялдан шинэ барилга байгууламж, гэр хорооллын өрхүүд албан ёсны зөвшөөрөлгүй худгийг олноор гаргасан байна. Зөвшөөрөлгүй худаг гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, өрх худгийн тооллого, бүртгэлд бүртгүүлэх, дэлгэрэнгүй мэдээллээ өгөхөөс шууд татгалзах, зугтах зэргээр нилээд саад учруулсан.

БОНХЯ, аймаг, нийслэлийн холбогдох албадаас худаг гаргаж, ашиглах боломжтой нутаг дэвсгэр, албан ёсны зөвшөөрөлтэй худаг гаргах аж ахуйн нэгжийг байнга зарлаж байх.

- Тооллогын үеэр эзэн нь тодорхойгүй буюу тухайн хороондоо бүртгэлгүй, байнга хүн оршин суудаггүй 500 орчим худагтай хашаа байв. Мөн Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмших, өмчлөх зөвшөөрөлгүй мөртлөө хашаа барьж суурьшсан өрх, аж ахуйн нэгжүүд маш их байсныг тооллогын явцад холбогдох дүүргийн газрын албанд тухай бүр мэдэгдсэн. Иймд хорооны “Хүн ам, өрхийн бүртгэл”, түүгээр байгуулдаг “Хүн ам” мэдээллийн санд түр оршин суугч болон тухайн хороонд үл хөдлөх хөрөнгө нь байдаг иргэнийг заавал бүртгэдэг журмыг боловсруулж мөрдөх нь зүйтэй байна.

- Өрх, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж буй бүх худагт усны тоолуур тавих.

- Тооллогод хамрагдсан боловч худгийн талаарх мэдээллээ өгөхөөс татгалзсан, эзэмшигч нь тодорхойгүй зэрэг шалтгаантай худаг бүрийг хороо, дүүргийн Засаг даргын холбогдох алба, нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Өмчийн харилцааны газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан шалгалт, үзлэгийг зохион байгуулах. Ялангуяа ашиглахгүй байгаа худгийг хаах.

- “Эрүүл, аюулгүй байдлын индекс” тооцох ажлын хүрээнд нэн тэргүүнд “Худгийн усыг зохих байгууллагаар шинжлүүлээгүй” гэсэн худаг бүрийг хороо, дүүргийн холбогдох ажлын албад шинжилгээнд хамруулах, цахилгаан, ус дамжуулах шугам сүлжээний холболтын аюулгүй байдлыг хангах ажлыг иргэдтэй хамтран зохион байгуулах.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

Маягт шивэх	
Тоологчийн мэдээлэл Шивэгчийн мэдээлэл	
Дугаар:	- Тоологчийг сонгоно уу -
Овог нэр:	
Утас:	
Ажилсан дүүрэг:	
Нэр	батбаяр
Гүний худгийн 2013 оны тооллого	
А. Хаягийн хэсэг	
№ Дугаар:	
1. Дүүргийн нэр:	1. Хан-Уул
2. Хороо дугаар:	
3. Гудам, хороолол:	
4. Хашаа, хаалганы дугаар:	
Б. Эзэмшигчийн мэдээлэл	
5. Эзэмшигч/ашиглагч өрхийн тэргүүний нэр:	
Эзэмшигч/ашиглагчийн регистрийн дугаар:	
6. Утасны дугаар:	
7. Эзэмшигч/ашиглагч аж ахуй нэгж, байгууллагын нэр:	
Байгууллагын регистрийн дугаар:	
8. Үйл ажиллагааны чиглэл:	
9. Утасны дугаар:	
10. Газрын гэрчилгээний нэгж салбарын дугаар:	
В. Ерөнхий мэдээлэл	
1. Худгийн нэр/дугаар:	
GPS:	
2. Худаг паспорттай эсэх:	1. Тийм
3. Худаг зөвшөөрөлтэй эсэх:	1. Тийм
4. Ашиглалтад орсон огноо /он.сар.өдөр/:	
5. Худгийн гүн /метр/:	
6. Худгийн цахилгаан үүсгүүр төвлөрсөн системд холбогдсон эсэх:	1. Тийм
7. Барилгын хийц:	1. Бетон
8. Хоногт дунджаар шахдаг усны хэмжээ, м³:	
9. Гүний худгийн барилгын талбайн хэмжээ, м²:	
10. Худгийн төрөл:	1. Өрөмдлөг
11. Худгийн зориулалт: /Жишээ нь: 1,3,4/	
12. Танай гүний худаг усан сантай эсэх:	1. Тийм
13. Усан сангийн тоо:	
14. Усан сангийн нийт багтаамж, м³:	
15. Шинжилгээ хийлгэсэн эсэх:	1. Тийм
16. Бүртгэл хийгдсэн огноо /он-сар-өдөр/:	
17. Шинэжилгээний лабораторийн нэр:	
18. Ашиглалтын байдал:	1. Ашиглаж байгаа
Тайлбар:	
Хадгалах	

Худаг тооллогын үр дүн

Map

Өрөмдлөг

Богоно яндант

Энгийн уурхайн

Бетон хашлагат уурхайн

Bogd Khan Uul
Богдхан уул ДЦГ

Bogd Khan Mountain
Богд-Хан-Уул

Zuunmod

Gorkhi Terej National Park

Зуунмодын зам

Харсрын зам

Айрт

Мандуурын зам

Төрөлж

Google

Map data ©2013 Google Terms of Use

Тоологч

Тоологч:
1. Түмэнжаргал
Хайх

Хайлт

Дүүрэг:
Бүгд
Хороо:

Эзэмшигч/ашиглагчийн нэр:

Эзэмшигч/ашиглагчийн регистр:

Аж ахуй нэгж, байгууллагын нэр:

Байгууллагын регистр:

Худаг зөвшөөрөлтэй эсэх:
Бүгд

Худгийн гүн:
☐ 10м-с бага
☐ 11-20м
☐ 21-30м
☐ 31м-с дээш
Худгийн төрөл:
☐ Өрөмдлөг
☐ Богино ядانت
☐ Энгийн уурхайн
☐ Бетон хашлагат уурхайн
Худгийн зориулт:
☐ 1. Унд, ахуй
☐ 2. Мал усалгаа
☐ 3. Газар тариалан
☐ 4. Үйлдвэрлэл
☐ 5. Бусад
Шинэжилгээ хийлгэсэн эсэх:
Бүгд
Ажиглалтынн байдал:
Бүгд
Хайх

Худаг тооллогын үр дүн

Map

Маягтын дугаар: 10
Тоологчийн нэр (дугаар): Одончимэг (17)
Эзэмшигчийн мэдээлэл
Нэр:
Регистр №:
Утас:
Гэрчилгээний дугаар:
Ерөнхий мэдээлэл
Худагын паспорт байхгүй.
Худаг зөвшөөрөлгүй.
Ашиглалтанд орсон огноо: 1997-08-15
Худгийн гүн: 6м
Худгийн цахилгаан үүсгүүр төвлөрсөн системд холбогдоогүй.
Барилгын хийц: Модон
Хоногт дунджаар шахдаг усны хэмжээ: 0.1м³
Гүний худгийн барилгын талбайн хэмжээ: 1м²
Худгийн төрөл: Энгийн уурхайн
Худгийн зориулт: унд, ахуй, газар тариалан
Шинэжилгээ хийлгээгүй.
Ашиглаж байгаа.

Хэрэглэгчийн хэсэг

» Нүүр хуудас

» Тайлан

» Хэрэглэгчийн тохиргоо

» Гарах

Бүх эрх хуулиар хамгаалагдсан © 2013 Нийслэлийн Статистикийн газар

Гүйцэтгэсэн: B.B-E

Худаг тооллогын үр дүн

Map data ©2013 Google Imagery ©2013 Cnes/Spot Image, DigitalGlobe, Landsat | Terms of Use

Google

Сүхбаатар

Гунт

Өрөмдлөг

Богино яндант

Энгийн уурхайн

Бетон хашлагат уурхайн



» 7 хоногийн үнэ

» Үнэ нэмэх

» Ажлын хүснэгт

» Асуулт хариулт

» Байгууллагын тохиргоо

» Баннер

» Бизнес регистр сан

» Гүний худаг

» И-мэйл илгээх

» Маягт, аргачлал, заавар

» Мэдээ мэдээлэл

» Статистик мэдээ

» Танилцуулга, судалгаа

» Хуудасны хандах эрх

» Хэрэглэгчийн тохиргоо

» Хэрэгцээт линк

Хэрэглэгчийн хэсэг

» Нүүр хуудас

» Хэрэглэгчийн тохиргоо

» Гарах

Тайлангийн төрөл

✓ Паспорт, зөвшөөрөлтэй эсэх

Харах

Дүн	Худгийн тоо	Худгийн паспортой эсэх								Худаг зөвшөөрөлтэй эсэх							
		Тийм				Үгүй				Тийм				Үгүй			
		Нийт	Өрхийн	ААНБ-ын	Эзэмшигч тодорхойгүй	Нийт	Өрхийн	ААНБ-ын	Эзэмшигч тодорхойгүй	Нийт	Өрхийн	ААНБ-ын	Эзэмшигч тодорхойгүй	Нийт	Өрхийн	ААНБ-ын	Эзэмшигч тодорхойгүй
Багануур	148	77	7	70	0	71	45	24	2	126	42	84	0	22	10	10	2
Багахангай	33	19	1	18	0	14	4	10	0	25	2	23	0	8	3	5	0
Баянгол	233	166	12	154	0	67	8	59	0	167	12	155	0	66	8	58	0
Баянзүрх	1,093	444	206	229	9	649	542	100	7	590	317	265	8	503	431	64	8
Налайх	256	211	24	187	0	45	13	32	0	152	12	140	0	104	25	79	0
Сонгинохайрхан	950	474	258	215	1	476	345	117	14	526	298	227	1	424	305	105	14
Сүхбаатар	1,309	727	616	76	35	582	551	26	5	764	652	77	35	545	515	25	5
Хан-Уул	1,089	592	270	322	0	497	363	127	7	595	263	332	0	494	370	117	7
Чингэлтэй	220	128	104	23	1	92	77	12	3	162	131	30	1	58	50	5	3
Дүн	5,331	2,838	1,498	1,294	46	2,493	1,948	507	38	3,107	1,729	1,333	45	2,224	1,717	468	39